



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ 2021/5



АГУУЛГА

		Хуудасны дугаар
	ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2017-2021 ОН	3
	АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
	НИЙГМИЙН ДААТГАЛ	5
	НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
	ЭРҮҮЛ МЭНД	8
	ГЭМТ ХЭРЭГ	10
	ҮНЭ ХАНШ	13
	МАЛ АЖ АХУЙ	16
	АЖ ҮЙЛДВЭР	16
	НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	18

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2020 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	194 501	45 365	13 151	43 314	55 421	37 250
Үүнээс:						
Тэмээ	205	43	-	160	2	-
Адуу	15 294	4 205	801	3 737	3 539	3 012
Үхэр	18 067	4 687	1 693	4 128	4 289	3 270
Хонь	92 137	21 859	5 970	20 699	27 076	16 533
Ямаа	68 798	14 571	4 687	14 590	20 515	14 435

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-V	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V
Суурин хүн ам	тоо	28 787	29 512	29 663	29342	
Төрөлт	тоо	233	285	256	249	251
Нас баралт	тоо	57	60	63	60	43
Шилжиж ирсэн	тоо	378	254	132	611	207
Цэвэр өсөлт	хувь	0.61	0.76	0.65	0.64	0.70'

' өмнөх оны суурин хүн амаас тооцов.

Зураг 1. Нутаг дэвсгэрийн хэмжээ






БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2021 оны 5 сарын эцэст 153 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 104 (1.7 дахин) хүнээр буурсан байна. Тайлант хугацаанд ажил хайж буй иргэдийн 1 (0.6%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг 2. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 118 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 62 (52.5%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Ажил хайгч иргэд, шалтгаанаар



Мөн энэ хугацаанд 33 иргэн ажилд зуучлуулан орсон ба төсөвт байгууллагад 1, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 5, улсын болон орон нутгийн үйлдвэрийн газарт 18, бусад хэлбэрийн байгууллагад 9 иргэн тус тус ажилд орсон байна.

Зураг 4. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 19 (12.4%) нь 15-24 насны, 54 (35.3%) нь 25-34 насны залуучууд, 34 (22.2%) нь 35-44 насныхан, 43 (28.1%) нь 45-60 насны, 3 буюу (2.0%) нь 60-аас дээш насны иргэд байна.

Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор, V сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2020 V	2021 V	2020 V	2021 V
Ажилгүйчүүд, бүгд	257	153	129	80
Үүнээс:				
Дээд боловсролтой	42	35	28	21
Тусгай дунд боловсролтой	12	7	4	5
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	46	19	17	3
Ерөнхий боловсролтой	152	86	78	49
Бага болон боловсролгүй	5	6	2	2

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 35 (22.9%) нь дээд боловсролтой, 7 (4.6%) нь тусгай дунд боловсролтой, 19 (12.4%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 86 (56.2%) нь ерөнхий боловсролтой, 6 (3.9%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 80 (52.3%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 8.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.4 (4.5%) тэрбум төгрөгөөр буурсан бол, зарлага 11.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 674.0 (6.2%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 5.6 (69.6%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 495.7 (6.2%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 565.7 (7.1%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 1.2 (15.9%) тэрбум төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 98.9 (1.2%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлт	2020		2021		$\frac{2021.V\%}{2020.V}$	$\frac{2021.I - V\%}{2020.I - V}$
	V	I-V	V	I-V		
	сая төгрөг					
Сангийн орлого, бүгд	844.7	8 382.8	1 448.1	8 005.4	171.4	95.5
тэтгэврийн сан	515.7	5 162.4	1 021.3	5 571.4	198.0	107.9
тэтгэмжийн сан	66.5	664.5	88.5	495.7	133.1	74.6
ажилгүйдлийн сан	14.3	142.4	17.2	98.9	120.3	69.5
ҮОМШӨ ¹ -ний сан	86.9	867.6	98.8	565.7	113.7	65.2
ЭМД ² -ын сан	161.3	1 545.9	222.3	1 273.7	137.8	82.4
Сангийн зарлага, бүгд	2 258.8	10 892.7	2 358.6	11 566.7	104.4	106.2
тэтгэврийн сан	1 958.5	9 543.7	2 099.9	1 0347.0	107.2	108.4
тэтгэмжийн сан	108.3	478.3	108.3	464.6	100.0	97.1
ҮОМШӨ-ний сан	151.7	705.8	130.5	657.7	86.0	93.2
ЭМД-ын сан	-	-	-	-	-	-
Ажилгүйдлийн сан	40.3	164.9	19.9	97.4	49.4	59.1

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

² Эрүүл мэндийн даатгал

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4581 хүнд 10.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 830 хүнд 464.6 сая төгрөгийн тэтгэмж, 212 хүнд 657.7 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 57 хүнд 97.4 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.




НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 5 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 920.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 753.8 (45.0%) сая төгрөгөөр буурсан байна. Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 886.7 (96.3%) сая төгрөг улсын төсвөөс, 30.0 (3.3%) сая төгрөг орон нутгийн төсвөөс, 3.9 (0.4%) сая төгрөг бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 441 хүнд 315.3 сая төгрөгийн тэтгэвэр, 373 хүнд 168.7 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, 449 ахмад настанд 18.6 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 2974 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 176.2 сая төгрөг, 216 хүнд амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 136.2 сая төгрөг, 2 хүнд онцгой тохиодлын тэтгэмж 2.4 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 49 иргэдэд 7.1 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Зураг 7. Нийгмийн халамжийн сангийн орлогын бүтэц



Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал

Үзүүлэлт	2020		2021		$\frac{2021.V\%}{2020.V}$	$\frac{2021.I - V\%}{2020.I - V}$
	V	I-V	V	I-V		
	Сая төгрөг					
Сангийн орлого	330.9	1 674.4	97.4	920.6	29.4	55.0
Улсын төсвөөс	330.3	1 635.6	96.7	886.7	29.3	54.2
Орон нутгийн төсвөөс	0.6	35.2	-	30.0	0.0	85.2
Бусад орлого	-	3.6	0.7	3.9	-	108.3
Сангийн зарлага	309.7	1 528.2	112.3	830.2	36.3	54.3
Тэтгэвэр	129.7	463.5	1.7	315.3	1.3	68.0
Тэтгэмж	33.1	158.1	33.3	168.7	100.6	106.7
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	31.9	97.9	33.2	136.2	104.1	139.1
"Алдарт эх" I одонт эхчүүд	-	120.0	-	-	-	0.0
"Алдарт эх" II одонт эхчүүд	0.3	133.3	-	-	0.0	0.0
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	-	8.5	-	-	-	0.0
Насны хишиг	0.1	114.1	-	-	0.0	0.0
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	2.8	12.0	-	-	0.0	0.0
*Дахин их						


Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	20.0	80.5	3.8	18.6	19.0	23.1
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	1.2	12.8	3.5	7.1	291.7	55.5
“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр	73.1	219.6	34.1	176.2	46.6	80.2
Цалинтай ээж	-	61.8	-	-	0.0	0.0
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	17.5	37.0	-	-	0.0	0.0
ОНО-д түшиглэсэн халамж	-	4.8	-	-	-	0.0
Ихэр хүүхдийн тэтгэмж	-	2.0	-	-	-	0.0
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	-	-	2.4	-	-
Бусад үйлчилгээ	0.1	2.3	2.7	5.7	2.7*	247.8



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 5 сарын байдлаар 262 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1 (0.4%) өссөн байна. Энэ хугацаанд 62161 хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 38770 (38.4%) хүнээр, хэвтэн эмчлүүлсэн 2242 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 1318 (37.0%) хүнээр тус тус буурсан байна.


Зураг 8. Амбулаторийн үзлэг 2021 оны V сар



Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл эхний 5 сард

Үзүүлэлт	2020 I- V	2021 I-V	$\frac{2021.I - V\%}{2020.I - V}$
Амаржсан эхийн тоо	263	258	98.1
Үүнээс бусад аймгийн харьяат	79	63	79.7
Амьд төрсөн хүүхэд	261	262	100.4
Үүнээс бусад аймгийн харьяат	78	64	82.1
Эхийн эндэгдэл	1	-	0.0
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	3	1	33.3

Зураг 9. Халдварт өвчин, сараар



2021 оны эхний 5 сарын байдлаар халдварт паразит өвчний 55 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 31.8%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 27 (32.9%) тохиолдлоор бүүрсан бол, цочмог халдварт өвчний 105 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 68.2%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 68 (2.1 дахин) тохиолдлоор өссөн байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 59.8 байгаа нь өмнөх оны мөн үеэс 14.3 продицимиллээр өссөн байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2020 I-V	2021 I-V	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	82	55	-27
Заг хүйтэн	51	27	-24
Тэмбүү	16	14	-2
Мөөгөнцөр /кандидоз/	2	1	-1
Трихомониаз	11	10	-1
Кандилом	1	2	1
Хламид	1	1	-
Цочмог халдварт өвчин	50	105	68
Цусан суулга	10	6	-4
Гепатит А	1	2	1
Салхин цэцэг	23	2	-21
Сальмонеллез	4	-	-4
Гар хөл амны өвчин	1	-	-1
Скарлатин	2	-	-2
Ковид-19	-	95	95
Сүрьеэ	6	13	7
Хоолны хордлого	3	-	-3
Нийт халдварт өвчин	132	173	41



ГЭМТ ХЭРЭГ


2021 оны эхний 5 сард дүүргийн хэмжээнд 58 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18 (23.7%) хэргээр буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 42.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.1 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2020 I-V	2021 I-V	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	76	58	-18	-23.7	100.0
Хүний амь нас хохирсон	3	-	-3	-100.0	0.0
Болгоомжгүйгээр хүний амь нас хохироосон	1	-	-1	-100.0	0.0
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	30	37	7	23.3	63.8
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	1	1	-	1.7
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	1	1	-	1.7
Бусдын эд хөрөнгө хулгайлах	15	2	-13	-86.7	3.4
Бэлгийн халдашгүй байдал	1	-	-1	-100.0	0.0
Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх	1	-	-1	-100.0	0.0
Дээрэмдэх	1	1	0	0.0	1.7
Залилан мэхлэх	9	5	-4	-44.4	8.6
Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах гэмтээх	1	-	-1	-100.0	0.0
Худал мэдээлэл тархаах	2	1	-1	-50.0	1.7
Гээгдэл эд зүйл завших алдаатай гүйлгээ хийх	5	2	-3	-60.0	3.4
Хөрөнгө завших	-	1	1	-	1.7
Мал хулгайлах	3	-	-3	-100.0	0.0
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах	1	-	-1	-100.0	0.0
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	3	1	-2	-66.7	1.7
Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	-	2	2	-	3.4
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	-	2	2	-	3.4
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	2	2	-	3.4
Хэрэг илрүүлэлтийн хувь	52.0	42.9			


Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 37 (63.8%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 5 (8.6%) нь залилан мэхлэх хэргүүд байна.

Зураг 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар




Тайлант хугацаанд бусдын эд хөрөнгө хулгайлах, гээгдэл эд зүйл завших, мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодис хууль бусаар ашиглах, хууль сахиулагчийг эсэргүүцэх, мөрийтэй тоглоом зохион байгуулах хэрэг тус бүр 2, гэр бүлийн хүчирхийлэл, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах, худал мэдээлэл тараах, хөрөнгө завших, бусдын эд хөрөнгө дээрэмдэх, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэргүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.

Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар



Зураг 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний V сард



Хүснэгт 9. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2020 I-V		2021 I-V	
	Согтуугаар	Гудамж талбайд	Согтуугаар	Гудамж талбайд
Бүгд	26	11	37	6
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	25	4	31	4
Гэр бүлийн хүчирхийлэл			1	
Бэлгийн халдашгүй байдал	1	-	-	-
Бусдын эд хөрөнгө хулгайлах	-	4	1	-
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	-	-	1	-
Залилан мэхлэх	-	1	-	-
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	-	2	-	1
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	-	2	1
Дүнд эзлэх хувь	34.2	14.5	63.8	10.3

Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг болон 37 болж өмнөх оны мөн үеэс 11 (42.3%) хэргээр өссөн бол, гудамж талбайд 6 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 (1.8 дахин) хэргээр буурсан байна. Мөн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 63.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 29.6 пунктээр нэмэгдсэн бол гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 10.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.2 пунктээр буурсан байна.

Зураг 13. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн V сар





ҮНЭ ХАНШ

2021 оны 5 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 10. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2021 оны 5 сарын дундаж үнэ


Хүнсний бараа		Хэмжээ нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг супер маркет
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1 700	1 700		1 700
	I зэрэг	кг	1 400	1 400		1 400
	II зэрэг	кг	1 050	1 000		1 000
Будаа	цагаан	кг	2 400	2 400		2 400
	шар	кг	2 050	2 100		3 000
Хонины мах	ястай	кг			11 000	
	цул	кг			12 500	
Үхрийн мах	ястай	кг			12 500	
	цул	кг			14 500	
Адууны мах, ястай		кг			9 500	
Ямааны мах		кг			10 000	
Элсэн чихэр		кг	2 200	2 300		2 300
Сүү /задгай/		л	2 500			
Тараг /задгай/		л	2 800			
Цөцгийн тос, Орос		кг	4 500	4 500		4 500
Байцаа		кг			2 300	
Манжин		кг			2 000	
Төмс	монгол	кг			1 000	
Лууван	монгол	кг			1 600	
Сонгино	хятад	кг			2 250	
	монгол	кг			3 025	
Сармис, булцуу		ш			500	
Огурцы, хятад		кг			8 750	
Помидор, хятад /үрлэн/		кг			9 875	
Ургамлын тос/ siesta/		ш	5 500	5 500		5 350
Өндөг		ш	500	500		500
Талх	Есөн шанд	том 900 гр	ш	2 000	2 000	2 000
		Дунд 700 гр	ш	1 800	1 800	1 800
		жижиг 500 гр	ш	1 500	1 500	1 500
	Атар талх		ш	1 200	1 200	1 200

Хүснэгт 11. Үйлчилгээний үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)


Үзүүлэлт	Хэмжин нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Дулаан	1м ²	660	1м ³	1632
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000	-	-
	40м ² - 80м ²	5 000		
	81м ² -аас дээш	10 000		
	1 хүн (тоолуургүй)	3 162		
Халуун ус	1м ³ (тоолууртай)	1 632	1 гкал	76 611
	Өвөл			
	1 хүн (тоолуургүй)	4 428		
	Зун			
Цэвэр ус*	1м ³ (тоолууртай)	1 632	1 л (тоолуургүй)	1.50
	1 хүн (тоолуургүй)	1.2		
	1 л (тоолууртай)	1.0		
	суурь хураамж	1 800		
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	1.2	1 л (тоолууртай)	1.8
	1 л (тоолууртай)	1.0		
	суурь хураамж	15.0		
	1 л (тоолуургүй)	1.4		

* 2019 оны 9 сарын 15-нээс мөрдөж байгаа тариф, 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос мөрдөж буй цэвэр, бохир усны тариф

Зураг 14. “Алтан тариа” гурилын дундаж үнэ, жил бүрийн 5-р сард



Зураг 15. Нэг кг махны дундаж үнэ, жил бүрийн 5-р сард



Хүснэгт 12. Цахилгааны үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	102.9
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	122.7
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	108.8
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	81.6
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай /бусад үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	133.0
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	214.3
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	81.6
3 тарифт тоолууртай /уул уурхай, боловсруулах аж үйлдвэр/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

* 2019 оны 5 сарын 1-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 13. Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ


	2018 V	2019 V	2020 V	2021 V
	төгрөг			
Адууны шир	20 000	6 000	8 000	7 000
Үхрийн шир /2.3 метрээс доош/	15 000	6 000	5 000	3 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	32 000	10 000	12 000	3 000
Хонины арьс	2 500	1 500	1 000	1 000
Ямааны ноолуур	83 000	100 000	52 500	100 000

Хүснэгт 14. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2017 V	2018 V	2019 V	2020 V	2021 V	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 480	1 580	1 850	1 450	1 450	0	0.0
АИ -92	1 630	1 730	1 960	1 493	1 470	-23	-1.5
Дизель түлш	1 720	2 050	2 430	2 180	2 180	0	0.0

2021 оны 5 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 23 төгрөгөөр (1.5) буурсан байна. Харин АИ-80 бензин, дизель түлшний үнэ өөрчлөгдөөгүй байна.

Зураг 16. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ, (чиглэл: УБ-БН, БН-УБ)



МАЛ АЖ АХУЙ

2021 оны эхний 5 сарын байдлаар 70970 эх мал төллөж 70970 төл гарснаас 2822 толгой төл мал хорогдсон байна. Энэ нь нийт гарсан төлийн 4.0 хувийг эзэлж байна. Одоогоор 68148 төл мал бойжиж байгаа ба төл бойжилт 96.0%-тай байна. Мал тооллогын дүнгээр энэ онд 90903 толгой эх мал төллөхөөс 70970 эх мал төллөсөн байгаа нь 78.1%-тай байна.

Хүснэгт 15. Том малын зүй бүс хорогдол

		Үүнээс:				
		Нийт хорогдол				
		Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1 хороо	73	7	5	-	43	18
2 хороо	38	5	6	-	12	15
3 хороо	601	46	48	-	297	210
4 хороо	128	4	10	-	52	62
5 хороо	553	28	40	-	111	374
ДҮН	1393	90	109	-	515	679

Тайлант хугацаанд зүй бусаар хорогдсон 1393 толгой том мал байгаагаас 325 (23.3%) толгой нь хээлтэгч мал байна. Нийт хорогдсон мал нь өнгөрсөн онд тоологдсон нийт малын 0.7 хувийг эзэлж байна. Нийт хорогдсон том малаас өвчнөөр хорогдсон 84 (6.0%) толгой мал байна.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2021 оны эхний 5 сард 68.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 7.6 (12.6%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 16. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2020 I-V	2021 I-V	$\frac{2021}{2020} \%$	2020 I-V	2021 I-V	$\frac{2021}{2020} \%$
Нүүрс олборлолт	м.тн	1 705.3	1 924.9	112.9	57 127.6	64 484.8	112.9
Дулаан дамжуулалт	м.гкал	86.2	87.1	101.0	3 081.4	3 202.7	103.9
Талх үйлдвэрлэлт	тн	84.3	86.4	102.5	118.8	124.3	104.6
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	18.8	25.0	133.0	155.4	242.4	156.0
Зайлуулсан хог хаягдал	м.м3	20.2	24.5	121.3	207.0	258.3	124.8
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					60 690.2	68 312.5	112.6


Зураг 17. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар




Оны эхний 5 сарын байдлаар нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 219.6 (12.9%) мянган тонн, үнийн дүнгээр 7.4 (12.9%) тэрбум төгрөгөөр, дулаан үйлдвэрлэлт 0.9 (1.0%) мянган гкал-аар, үнийн дүнгээр 121.3 (3.9%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2.1 (2.5%) тонноор, үнийн дүнгээр 5.5 (4.6%) сая төгрөгөөр, нарийн боовны үйлдвэрлэлт 6.2 (33.0%) тонноор буюу 87.0 (56.0%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд 24.5 мянган м3 хог зайлуулсан нь өнгөрсөн оноос 4.3 (21.3%) мянган м3-аар нэмэгджээ.

Зураг 18. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, сая төгрөг



Зураг 19. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн V сард




НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 913.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 13.4 (1.5%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 468.2 (51.2%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 17. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

Үзүүлэлт	2020 I-V	2021 I-V	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	900.3	913.7	13.4
Орон сууц	206.7	229.4	22.7
Ус борлуулалт, бүгд	340.2	363.5	23.3
Хүн амд	201.4	190.9	-10.5
Аж ахуйн нэгжид	138.8	172.6	33.8
Сувагжуулалт	302.5	289.5	-13
Бусад	50.9	31.3	-19.6

Зураг 20. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 18. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	241 059.7	198 149.3	82.2
Тавлаг өргөө	41 252.5	31 651.1	76.7
Маргад өргөө	43 969.4	32 362.4	73.6
Сод хөгжил	53 624.5	49 394.6	92.1
Шинэ элч	42 978.3	31 010.8	72.2
Уурхайчин	33 541.0	32 180.4	95.9
Содон суварга	25 694.0	21 550.0	83.9

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2021 оны 6 дугаар сарын 14

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 







аппликейшнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn